179

ДОРНОГОВЬ АЙМАГ
**“ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ СТАНЦ”**
**ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ЗАХИРЛЫН**
**ТУШААЛ**

2023 оны 12 сарын 27 өдөр Дугаар А/139 Борхойн тал

Журамд нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10, 11, Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1, Засгийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 123 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Замын-Үүдийн дулааны станц” Төрийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, 6.5.7 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 342 дугаар тогтоол, Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2.1.5, 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3.1.11 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 342 дугаар тогтоолоор “Замын-Үүдийн дулааны станц“ төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулалтын бүтцийн схем, албан тушаалын жагсаалт шинэчлэн батлагдсантай холбогдуулан “Ажилчдад сарын, жилийн үйл ажиллагааны үр дүнгийн, нөхцөлийн, ур чадварын нэмэгдэл олгох журмын хэлтэс, алба, хэсгийн ажилтнуудын албан тушаалын нэршилд өөрчлөлт оруулан нэгдүгээр хавсралтаар, Хэлтэс, алба, хэсгийн сарын үр дүнгийн нэмэгдэл олгох хувь тооцох хүснэгтүүд 1-10”-ийн албан тушаалын нэршилд өөрчлөлт оруулан хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Үйл ажиллагааны үр дүнг батлагдсан журам, Захирлын зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу тооцон олгохыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Болортуяа)-д зөвшөөрсүгэй.

3.Батлагдсан журмыг хэрэгжүүлэн, мөрдөж ажиллахыг хэлтэс хэсгийн удирдлагуудад үүрэг болгосугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан “ Журам батлах тухай” Захирлын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/06 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэ тушаалыг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ЗАХИРАЛ О.ТӨМӨРХУЯГ

4401301231276

180

Захирлын 2023 оны 12 дугаар сарын 27 - ны өдрийн
А/139 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

# АЖИЛЧДАД САРЫН, ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН НӨХЦӨЛИЙН, УР ЧАДВАРЫН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

2023.12.25 Замын-Үүд сум

**Журмын зорилго:** "Замын-Үүдийн дулааны станц" ТӨҮГ-ын нийт ажилчдад сарын үр дүнгийн нэмэгдэл, нөхцөлийн нэмэгдэл, ур чадварын нэмэгдэл, жилийн үр дүнгийн нэмэгдэл олгоход оршино.

**Нийтлэг үндэслэл:** Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам Захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан 2022-2023 оны Хамтын гэрээний холбогдох заалтуудыг үндэслэл болгоно.

## Нэг.Нөхцөлийн нэмэгдэл

1.1 Хэвийн бус ажлын горимтой буюу ажлын байр нь хэвийн бус нөхцөлд тооцогддог дараах албан тушаалтанд нөхцөлийн нэмэгдэл хөлс олгоно. Үүнд:

**а/ Дотоод хяналтын алба**

Хөдөлмөр хамгааллын инженер- 30,000 төгрөг
Хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтан- 30,000 төгрөг

**б/ Захиргаа, удирдлагын хэлтэс**

Технологи,удирдлагын системийн программист инженер-30,000 төгрөг
Үйлдвэрийн цэвэрлэгээ, үйлчилгээний ажилтан- 30,000 төгрөг

**в/ Ус хангамж, Ариутгах татуургын хэсэг**

- Ус хангамжийн инженер- 30,000 төгрөг
- Ариутгах татуургын инженер- 30,000 төгрөг
- Бохир усны төвлөрсөн цэвэрлэх байгууламжийн ээлжийн техникч-60,000 төгрөг
- Бохир усны цэвэрлэх байгууламжийн ээлжийн машинч-60,000 төгрөг
- Бохир ус сорох машины жолооч - 60,000 төгрөг
- Бохир усны шугам хоолойн засварчин- 160,000 төгрөг

- Химич – 30,000 төгрөг

**г/ Зуухан цех**

- Ашиглалтын ахлах инженер-30,000 төгрөг
- Зуухан цехийн горимын инженер-30,000 төгрөг
- Станцын ээлжийн инженер- 50,000 төгрөг
- Химийн инженер -30,000 төгрөг
- Лаборант- 30,000 төгрөг
- Зуухны машинч- 30,000 төгрөг
- Зуухны туслах машинч- 50,000 төгрөг
- Туслах тоноглолын машинч-50,000 төгрөг
- Түлш дамжуулахын машинч – 50,000 төгрөг

- Эрчим хүчний хэмнэлт тооцооны инженер-30,000 төгрөг

**д/ Засвар үйлчилгээний хэсэг**

- Засварын ахлах инженер-30,000 төгрөг
- Нарийн хэмжүүр автоматикийн инженер -30,000 төгрөг
- Цахилгааны инженер-30,000 төгрөг
- Тоног төхөөрөмжийн засварчин-30,000 төгрөг
- Цахилгааны монтёр-30,000 төгрөг
- Цахилгаан ба хийн гагнуурчин-50,000 төгрөг

**е/ Авто хэсэг**

- Хүнд машин механизмын засварчин- 30,000 төгрөг
- Хүнд даацын машины жолооч- 30,000 төгрөг
- Түлш дамжуулахын нүүрс түрдэг тракторчин-30,000 төгрөг

**ё/ Дулаан, Шугам сүлжээний хэсэг**

- Дулаан, шугам сүлжээний ашиглалтын инженер-30,000 төгрөг
- Дулааны шугам сүлжээний засварын инженер-30,000 төгрөг
- Гагнуурчин -50,000 төгрөг
- Сантехникийн засварчин-50,000 төгрөг
- Үл хамаарах системтэй дулаан хуваарилах төвийн машинч-30,000 төгрөг

1.2Нөхцөлийн нэмэгдэл хөлсийг зөвхөн тухайн албан тушаалыг эрхэлж буй хугацаанд албан тушаалын үндсэн цалин дээр сар бүр тогтмол олгогдоно. Хавсран, орлон ажиллаж буй ажилтанд олгохгүй.

## Хоёр.Ур чадварын нэмэгдэл

2.1.Эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэдэг, бусдаас илүү дэвшилтэт арга барилаар, ажлын өндөр бүтээл гарган, хамт олноо манлайлан ажилладаг ажилтанд ур чадварын нэмэгдэл олгоно.

2.2.Ур чадварын нэмэгдлийг мэргэжлийн дагуу ажилласан үндсэн ажилтанд шалгуур үзүүлэлтийн холбогдох заалтыг хангасан тохиолдолд захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн захирлын тушаалаар батлан олгоно.

2.3.Ур чадварын нэмэгдэл хөлсний хэмжээ нь тухайн ажилтны ажилласан жил, ур чадварын шалгуур үзүүлэлтийн үнэлгээг харгалзан Хамтын гэрээнд заасны дагуу 40 хүртэл хүртэл хувиар үндсэн цалингаас тооцон олгоно.

## Гурав. Сарын үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох талаар

Ажилчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх, ажиллах идэвхи санаачлагыг нэмэгдүүлэх зорилгоор сарын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг сарын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, гүйцэтгэлээр тооцож олгоно.

## Сарын үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэнэ

3.1.Сарын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг Хамтын гэрээний холбогдох заалтыг үндэслэн үндсэн цалингийн 30 хүртэлх хувиар тооцон олгоно.

3.2.Тухайн сарын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж хувь, хэмжээг тогтооно.

3.3.Захирлын зөвлөл нь тухайн сарын Техник эдийн засгийн үзүүлэлт буюу үйлдвэрлэлийн хэвийн тасралтгүй үйл ажиллагаа, борлуулалтын орлогын төлөвлөгөөний биелэлт, ХАБЭА хууль, дүрэм, журам заавар зөрчсөн эсэхийг харгалзан сарын үр дүнг дараах шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд олгох бөгөөд сарын үйл ажиллагааг дүгнэх, нэмэгдэл хөлс олгох явц нь шударга, хамт олонд нээлттэй байх зарчмыг баримтлана.

**Үндсэн 30 хувийг дараах заалтыг харгалзан тогтооно.**

Үүнд:

- ТЭЗҮ буюу Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа -10%
- Санхүү, Борлуулалтын орлогын төлөвлөгөөний биелэлт 80 ба түүнээс дээш хувиар биелсэн болон бусад ажлын үр дүнгийн үзүүлэлт, гүйцэтгэлийг үнэлсэн байдал -10%
- ХАБЭА зөрчилгүй, аваар осол саатал гаргаагүй байдал- 10%

3.4.Захирлын зөвлөлөөс Үндсэн шалгуур үзүүлэлтээр тогтоосон хувийг хэлтэс , алба, хэсэг нэгж хариуцсан инженер, удирдлагууд - ажилтан тус бүрээр шалгуур үзүүлэлтээр /Хүснэгт №1-9/ хэлэлцэн хуралдаж тухайн сарын ажлыг дүгнэж захирлаар

хянуулан батлуулж, /Хурлын тэмдэглэл хавсаргасан байх/, Тооцооны нягтлан бодогчид тухайн сарын 23-ны өдөр хүлээлгэн өгнө.

3.5.Ажилтнуудын сарын үйл ажиллагааг дүгнэсэн хуудас, хурлын тэмдэглэлийг тогтоосон хугацаанд Тооцооны нягтлан бодогчид хүлээлгэн өгөөгүй бол сарын үйл ажиллагааны нэмэгдэл хөлсийг тухайн сард олгохгүй.

3.6.Хэлтэс, Алба, хэсгийн дарга нарын үр дүнгийн нэмэгдлийг Хүснэгт №4-т заасан үзүүлэлтээр Захиргаа, удирдлагын хэлтсийн даргаар дүгнүүлж, захирлаар хянуулж, батлуулна.

3.7.Хяналтын албаны ажилчдын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг Хүснэгт №6-д заасан үзүүлэлтээр захирал дүгнэж батална.

3.8Удирдлагын үр дүнгийн нэмэгдлийг Хүснэгт №10-т заасан үзүүлэлтээр захирал дүгнэж батална.

3.9. Дулаан шугам сүлжээний хэсгийн ажилчдын үр дүнгийн нэмэгдлийг Хүснэгт №1,

-Захиргаа, удирдлагын хэлтсийн ажилчдын үр дүнгийн нэмэгдлийг Хүснэгт №2,

-Санхүү, борлуулалтын хэлтсийн ажилчдын үр дүнгийн нэмэгдлийг Хүснэгт №3,

-Авто хэсгийн ажилчдын үр дүнгийн нэмэгдлийг Хүснэгт №5,

-Засвар үйлчилгээний хэсгийн ажилчдын үр дүнгийн нэмэгдлийг Хүснэгт №7,

-Дулаан, шугам сүлжээний хэсгийн ажилчдын үр дүнгийн нэмэгдлийг Хүснэгт №8,

-Ус хангамж ариутгах татуургын хэсгийн ажилчдын үр дүнгийн нэмэгдлийг Хүснэгт №9,

-Удирдлагын үр дүнгийн нэмэгдлийг Хүснэгт №10-д заасан үзүүлэлтээр тус тус хэлтэс, алба, хэсгийн дарга нар дүгнүүлж, захирлаар хянуулж, батлуулна.

-Хэлтэс, алба, хэсгийн ажилчидад сарын үр дүнгийн хувь тооцох Хүснэгт № 11

3.10.Тухайн сард алба, хэсгүүдэд олгох шагналт цалинг бууруулах, олгохгүй байх эрхийг захирал эдлэх бөгөөд хэлтэс, алба, хэсгийн дарга, инженер, удирдах албан тушаалтан нар нь үр бүтээл муутай ажилласан, ажил дүгнэх үзүүлэлтээр хангалтгүй үнэлэгдсэн ажилтнуудын шагналт цалинг бууруулах буюу олгохгүй байх эрхтэй. /Тайлан, баримт, үндэслэлтэй байх./

## <u>Дөрөв. Сарын үр дүнгийн нэмэгдэл хөлсийг бууруулах буюу олгохгүй</u>

Дараах тохиолдолд сарын үр дүнгийн нэмэгдэл хөлс олгохгүй, бууруулах. Үүнд:

4.1.Ажилтан албан хаагч нь байгууллагад хохирол учруулсан, өр авлага үүсгэсэн

4.2.Технологийн горим зөрчигдсөн, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа тасалдсан, аваар осол гэмтэл гарсан тохиолдолд, тухайн зөрчил гаргасан хэсгүүдийн үр дүнг бууруулна.

Бусад байгууллагын буруугаас эсвэл хэрэглэгчдийн өөрийн мэдлийн төхөөрөмжийн доголдлоос болж гэмтэл, саатал гарсан, давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан нь тогтоогдсон бол сарын үйл ажиллагааг дүгнэж нэмэгдэл хөлс олгоно.

4.3.Байгууллагаас зохион байгуулсан олон нийтийн ажил, соёл урлаг, спортын ажилд хэлтэс, алба, хэсгээ бүрэн хамруулаагүй бол тухайн алба хэсгүүдийн үр дүнг бууруулна.

4.4.Ээлжийн амралттай, өвчтэй, хувийн чөлөөтэй, ажил тасалсан, хүүхэд асрах чөлөөтэй хугацаанд олгохгүй.

## Тав. Жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлс олгох талаар

5.1Жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг үндсэн цалинг 100 хүртэл хувиар тооцон захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, захирлын тушаалаар батлан дараа оны нэгдүгээр сард багтаан нэг удаа олгоно.

5.2 Ажилтанд жилийн үр дүнгийн нэмэгдэл хөлсийг цагийн бүртгэлийг үндэслэн тухайн жилд ажилласан хоногоор буюу ажилласан хугацаанд ногдуулан тооцон олгоно.

5.3 Ажилтны сул зогсолтод хамрагдсан хугацаа, төрөхийн өмнөх болон төрсний дараах эмнэлгийн чөлөөтэй хугацаа, хувийн олговортой чөлөөний хугацааг ажилласан хугацаанд тооцон олгоно.

5.4 Үндсэн ажилтан нас барсан тохиолдолд тухайн жилд ажилласан хугацаанд нь ногдох жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг ар гэрт нь олгоно.

5.5 Өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн ажилтан тухайн жилд 9 сар хүртэл ажилласан бол ажилласан хугацаанд нь ногдуулан тооцон олгоно.

5.6Тэтгэвэрт гарсан, ажлын байр хасагдсан, орон тоо цөөрсөн, нэгж татан буугдсан, эрүүл мэндийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй нь Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр тогтоогдсон үндэслэлээр тус тус ажлаас чөлөөлөгдсөн иргэнд тухайн жилд ажилласан хугацаанд нь ногдохоор тооцон олгоно. Үйлдвэрийн газрын захирлаар ажиллаж байсан иргэнд уг заалт хамаарахгүй.

## Зургаа. Жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгохгүй

Дараах тохиолдолд жилийн үйл ажиллагааны үр дүнгийн нэмэгдэл хөлсийг олгохгүй. Үүнд:

6.1.Байгууллагад хөрөнгийн хохирол учруулсан нь хууль хяналт болон эрх бүхий байгууллагаар тогтоогдсон бол.

6.2.Өвчтэй, хувийн чөлөөтэй, ажил тасалсан, хүүхэд асрах чөлөөтэй хугацаанд

6.3.Өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн ажилтан тухайн жилд 9 сар хүртэл ажиллагаагүй бол.

6.4.Ажил олгогчийн санаачлагаар хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь хөдөлмөрийн сахилгын шийтгэлээр цуцлагдсан бол.

6.5Ажилтан ажиллах хугацаандаа ажлаа зохих ёсоор хүлээлцээгүй, ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ өгөөгүй, ажлын байрыг орхиж явсан, холбогдох тооцоог хийж дуусгаагүй бол.

6.6.Энэхүү журмын 6 дугаар зүйлд тусгагдаагүй асуудлыг Захирал шийдвэрлэнэ.

-o0o-

Захирлын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн А/139 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт, хүснэгт №1

БАТЛАВ: “ЗҮДС” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ .............................. /О.ТӨМӨРХУЯГ/

## Дулаан, шугам сүлжээний хэсэгт ............. сарын үр дүнгийн нэмэгдэл олгох хувь тооцох хүснэгт

......... он ......... сарын ....өдөр

| Д/д | Үзүүлэлт | Олгох ёстой хувь | Олгосон хувь | Дүгнэх албан тушаалтан | Гарын үсэг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тоног төхөөрөмжийн бэлэн байдал, зогсолт, саатал, ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байдал | 15% | | Захирал | | |
| | | | | Ерөнхий инженер | | |
| 2 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм мөрдөж, зөрчилгүй ажилласан байдал | 20% | | ХАБЭА инженер | | |
| 3 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт | 20% | | Захирал | | |
| | | | | Ерөнхий инженер | | |
| 4 | Цаг ашиглалт, олон нийтийн ажилд оролцсон байдал, ёс зүй харилцаа хандлагын зөрчилгүй, Газрын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрэм, журмын зөрчилгүй байдал | 15% | | Хууль, гэрээний мэргэжилтэн | | |
| | | | | Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн | | |
| 5 | Ажлын чанар, параметрийн барилт, горим ажиллагаа, бусад дүрэм, заавар мөрдөж ажилласан байдал | 10% | | Ерөнхий инженер | | |
| 6 | Хоногийг үзүүлэлтийн хөтлөлт | 10% | | Зуухан цехийн горимын инженер | | |
| 7 | Мэдээ, тайлан хугацаанд нь гаргасан байдал, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт | 10% | | Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга | | |
| | | | | Ерөнхий нягтлан бодогч | | |
| Дүн | | 100% | | | | |

Дүгнэсэн: Ерөнхий инженер.......................................... /.................................../

Захирлын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн А/139 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт, хүснэгт №2

БАТЛАВ: "ЗҮДС" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ ................................ /О.ТӨМӨРХУЯГ/

**Захиргаа, удирдлагын хэлтсийн .............. сарын үр дүнгийн нэмэгдэл олгох хувь тооцох хүснэгт**

......... он ...... сарын .... өдөр

| Д/д | Үзүүлэлт | Олгох ёстой хувь | Олгосон хувь | Дүгнэх албан тушаалтан | Гарын үсэг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийн биелэлт, хариуцсан ажлын чанар, үзүүлэлт, | 20% | | Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга | | |
| 2 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, | 20% | | | | |
| 3 | Мэдээ, тайлан хугацаанд нь гаргасан байдал, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт | 10% | | | | |
| 4 | Цаг ашиглалт, олон нийтийн ажилд оролцсон байдал, ёс зүй харилцаа хандлагын зөрчилгүй, Газрын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрэм, журмын зөрчилгүй байдал | 20% | | Хууль, гэрээний мэргэжилтэн | | |
| | | | | Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн | | |
| 5 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм журам мөрдөж, зөрчилгүй ажилласан байдал | 30% | | ХАБЭА инженер | | |
| Дүн | | 100% | | | | |

Дүгнэсэн: Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга ......................... /....................................../

Захирлын 2023 оны 12 сарын 27 ны өдрийн А/139 дүгээр
тушаалын хоёрдугаар хавсралт, хүснэгт №3

БАТЛАВ: "ЗҮДС" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ ......................... /О.ТӨМӨРХУЯГ/

**Санхүү, борлуулалтын хэлтсийн ............... сарын үр дүнгийн нэмэгдэл олгох хувь тооцох хүснэгт**

....... оны ....... сарын.....өдөр

| Д/д | Үзүүлэлт | Олгох ёстой | Олгосон хувь | Дүгнэх албан тушаалтан | Гарын үсэг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өмч хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, Орлогын төлөвлөгөөний биелэлт, өр авлагыг өмнөх сараас бууруулсан байдал | 20% | | Захирал | | |
| | | | | Захиргаа удирдлагын хэлтсийн дарга | | |
| 2 | Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг үнэн зөв алдаагүй хөтөлсөн, Санхүүгийн сарын төлөвлөгөө тайлан мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь тайлагнасан байдал | 20% | | Захирал | | |
| | | | | Ерөнхий нягтлан бодогч | | |
| 3. | Цаг ашиглалт, олон нийтийн ажилд оролцсон байдал, Ёс зүй харилцаа хандлагын зөрчилгүй, Газрын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрэм, журмын зөрчилгүй байдал | 20% | | Хууль, гэрээний мэргэжилтэн | | |
| | | | | Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн | | |
| 4 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлж ажилласан байдал, хариуцсан ажлын чанар үзүүлэлт. | 15% | | Захирал | | |
| | | | | Захиргаа удирдлагын хэлтсийн дарга | | |
| | | | | Ерөнхий нягтлан бодогч | | |
| 5 | ХАБЭА-н хууль, дүрэм мөрдөж, зөрчилгүй ажилласан байдал, | 10% | | ХАБЭА инженер | | |
| 6 | Шилэн дансыг хугацаанд нь алдаагүй хөтөлж, дотоод хяналтын албанаас ирүүлсэн зөвлөмж, үүрэг даалгаварыг хугацаанд нь биелүүлсэн, тайлагнасан байдал, бараа ажил үйлчилгээ, худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан байдал | 15% | | Захирал | | |
| | | | | Захиргаа удирдлагын хэлтсийн дарга | | |

Дүгнэсэн: Ерөнхий нягтлан бодогч .......................... /......................................./

188

Захирлын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн А/239 дүгээр
тушаалын хоёрдугаар хавсралт, хүснэгт №4

БАТЛАВ: "ЗҮДС" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ ................................/ О.ТӨМӨРХУЯГ

## Хэлтэс, хэсгийн дарга нарын ......... сарын үр дүнгийн нэмэгдэл олгох хувь тооцох хүснэгт

……он……сарын….өдөр

| Д/д | Үзүүлэлт | Олгох ёстой хувь | Олгосон хувь | Дүгнэх албан тушаалтан | Гарын үсэг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өгсөн үүрэг даалгавар, төлөвлөгөөний биелэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлүүлж, хариу өгсөн байдал | 20% | | Захирал | | |
| | | | | Ерөнхий инженер | | |
| 2 | Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зөрчилгүй байдал, дотоод хяналтын албанаас ирүүлсэн зөвлөмж, үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлсэн, тайлагнасан байдал | 10% | | Дотоод хяналтын мэргэжилтэн | | |
| 3 | Хариуцсан ажлын чанар, тоноглолын бэлэн байдал, горим ажиллагаа, мэдээ тайлан хугацаанд нь гаргах, ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байдал | 30% | | Захирал | | |
| | | | | Ерөнхий инженер | | |
| 4 | Цаг ашиглалт, олон нийтийн ажилд оролцсон байдал, ёс зүй харилцаа хандлагын зөрчилгүй, Газрын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрэм, журмын зөрчилгүй байдал | 20% | | Хууль, гэрээний мэргэжилтэн | | |
| | | | | Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн | | |
| 5 | ХАБЭА хууль, дүрмийг мөрдөж зөрчилгүй ажилласан байдал | 20% | | ХАБЭА инженер | | |
| Дүн | | 100% | | | | |

Дүгнэсэн: Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга .................................... /................................../

Захирлын 2023 оны 12 сарын 27 ны өдрийн А/138 дугээр тушаалын хоёрдугаар хавсралт, хүснэгт №5

БАТЛАВ: "ЗҮДС" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ ................................/О.ТӨМӨРХУЯГ/

## Авто, хэсгийн ажилчдын ......... сарын үр дүнгийн нэмэгдэл олгох хувь тооцох хүснэгт

......он......сарын....өдөр

| Д/д | Үзүүлэлт | Олгох ёстой хувь | Олгосон хувь | Дүгнэх албан тушаалтан | Гарын үсэг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг графикт хугацаанд нь чанартай гүйцэтгэж, аюулгүй байдлыг хангасан байдал | 20% | | Захирал | | |
| | | | | Ерөнхий инженер | | |
| 2 | Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зөрчилгүй байдал, | 10% | | Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга | | |
| 3 | - Тээврийн хэрэгсэл, жолоочийн эрүүл мэнд, бичиг баримтын үзлэгийг ажилд гарахын өмнө тогтмол шалгасан байдал,<br>- Ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байдал,<br>- Ахуйн байр, авто граж, тээврийн хэрэгслийн цэвэрлэгээг тогтмол хийсэн байдал<br>- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийн зөрчилгүй бол | 30% | | Захирал | | |
| | | | | Ерөнхий инженер | | |
| 4 | Цаг ашиглалт, олон нийтийн ажилд оролцсон байдал, ёс зүй харилцаа хандлагын зөрчилгүй, Газрын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрэм, журмын зөрчилгүй байдал | 20% | | Хууль, гэрээний мэргэжилтэн | | |
| | | | | Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн | | |
| 5 | ХАБЭА хууль, дүрмийг мөрдөж зөрчилгүй ажилласан байдал | 20% | | ХАБЭА инженер | | |
| Дүн | | 100% | | | | |

Дүгнэсэн: Автын инженер .................................. /................................../

190

Захирлын 2023 ...оны 12 ....сарын 27 ...ны өдрийн А/59 ...дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт, хүснэгт №6

БАТЛАВ: "ЗҮДС" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ ................................. /О.ТӨМӨРХУЯ /

## Дотоод хяналтын албанд .......... сарын үр дүнгийн нэмэгдэл олгох хувь тооцох хүснэгт

......... он ...... сарын .... өдөр

| Д/д | Үзүүлэлт | Олгох ёстой хувь | Олгосон хувь | Дүгнэх албан тушаалтан | Гарын үсэг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийн биелэлт, хариуцсан ажлын чанар, үзүүлэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлүүлж, хариу өгсөн байдал | 20% | | Захирал | | |
| 2 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт, | 20% | | | | |
| 3 | Мэдээ, тайлан хугацаанд нь гаргасан байдал, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт | 10% | | | | |
| 4 | Цаг ашиглалт, олон нийтийн ажилд оролцсон байдал, ёс зүй харилцаа хандлагын зөрчилгүй, Газрын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрэм, журмын зөрчилгүй байдал | 20% | | Хууль, гэрээний мэргэжилтэн | | |
| | | | | Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн | | |
| 5 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм журам мөрдөж, зөрчилгүй ажилласан байдал | 30% | | ХАБЭА инженер | | |
| Дүн | | 100% | | | | |

Дүгнэсэн: Дотоод хяналтын мэргэжилтэн ......................... /....................................../

Захирлын 2021 оны 12 сарын 27 ны өдрийн А/89 дүгээр
тушаалын хоёрдугаар хавсралт, хүснэгт №7

БАТЛАВ: "ЗҮДС" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ .................................. /О.ТӨМӨРХУЯГ/

**Засвар, үйлчилгээний хэсэгт ............. сарын үр дүнгийн нэмэгдэл олгох хувь тооцох хүснэгт**

.......... он ......... сарын ....өдөр

| Д/д | Үзүүлэлт | Олгох ёстой хувь | Олгосон хувь | Дүгнэх албан тушаалтан | Гарын үсэг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тоног төхөөрөмжийн бэлэн байдал, зогсолт, саатал, дуулгагыг шуурхай богино хугацаанд устгаж, ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргээ чанартай хэрэгжүүлж ажилласан байдал | 15% | | Захирал | | |
| | | | | Ерөнхий инженер | | |
| 2 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм мөрдөж, зөрчилгүй ажилласан байдал | 20% | | ХАБЭА инженер | | |
| 3 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт | 20% | | Захирал | | |
| | | | | Ерөнхий инженер | | |
| 4 | Цаг ашиглалт, олон нийтийн ажилд оролцсон байдал, ёс зүй харилцаа хандлагын зөрчилгүй, Газрын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрэм, журмын зөрчилгүй байдал | 15% | | Хууль, гэрээний мэргэжилтэн | | |
| | | | | Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн | | |
| 5 | Ажлын чанар, параметрийн барилт, горим ажиллагаа, бусад дүрэм, заавар мөрдөж ажилласан байдал | 10% | | Ерөнхий инженер | | |
| 6 | Мэдээ, тайлан хугацаанд нь гаргасан байдал, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт | 10% | | Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга | | |
| Дүн | | 100% | | | | |

Дүгнэсэн: Засварын ахлах инженер .................................. /................................../

Захирлын 2023 оны 12 сарын 27 ны өдрийн А/39 дугээр
тушаалын хоёрдугаар хавсралт, хүснэгт №8

БАТЛАВ: "ЗҮДС" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ ..................................... /О.ТӨМӨРХУЯГ/

## Зуухан цех ............. сарын үр дүнгийн нэмэгдэл олгох хувь тооцох хүснэгт

.......... он ......... сарын ....өдөр

| Д/д | Үзүүлэлт | Олгох ёстой хувь | Олгосон хувь | Дүгнэх албан тушаалтан | Гарын үсэг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Тоног төхөөрөмжийн бэлэн байдал, зогсолт, саатал, дуулгагыг шуурхай богино хугацаанд устгаж, ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргээ чанартай хэрэгжүүлж ажилласан байдал | 15% | | Захирал | | |
| | | | | Ерөнхий инженер | | |
| 2 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм мөрдөж, зөрчилгүй ажилласан байдал | 20% | | ХАБЭА инженер | | |
| 3 | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт | 20% | | Захирал | | |
| | | | | Ерөнхий инженер | | |
| 4 | Цаг ашиглалт, олон нийтийн ажилд оролцсон байдал, ёс зүй харилцаа хандлагын зөрчилгүй, Газрын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрэм, журмын зөрчилгүй байдал | 15% | | Хууль, гэрээний мэргэжилтэн | | |
| | | | | Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн | | |
| 5 | Ажлын чанар, параметрийн барилт, горим ажиллагаа, бусад дүрэм, заавар мөрдөж ажилласан байдал | 10% | | Ерөнхий инженер | | |
| 6 | Төлбөрт үйлчилгээний захиалгын хуудас болон гэрээгээр гүйцэтгэсэн ажлын мэдээ тайлан, баримтыг тухай бүртээ Санхүү борлуулалтын албанд хүлээлгэн өгсөн байдал. | 10% | | Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга | | |
| 7 | Мэдээ, тайлан хугацаанд нь гаргасан байдал, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт | 10% | | Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга | | |
| | | | | Ерөнхий нягтлан бодогч | | |
| Дүн | | 100% | | | | |

Дүгнэсэн: Ашиглалтын ахлах инженер .................................. /.................................../

Захирлын 2023 оны 12 сарын 27 ны өдрийн А/139 дүгээр
тушаалын хоёрдугаар хавсралт, хүснэгт №9

БАТЛАВ: “ЗҮДС” ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ ..................................... /О.ТӨМӨРХУЯГ/

**Ус хангамж, ариутгах татуургын хэсэг ............. сарын үр дүнгийн нэмэгдэл олгох хувь тооцох хүснэгт**

......... он ......... сарын ....өдөр

| Д/д | Үзүүлэлт | Олгох ёстой хувь | Олгосон хувь | Дүгнэх албан тушаалтан | Гарын үсэг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Тоног төхөөрөмжийн бэлэн байдал, зогсолт, саатал, дуулгагыг шуурхай богино хугацаанд устгаж, ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргээ чанартай хэрэгжүүлж ажилласан байдал | 15% | | Захирал | | |
| | | | | Ерөнхий инженер | | |
| 2. | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль, дүрэм мөрдөж, зөрчилгүй ажилласан байдал | 20% | | ХАБЭА инженер | | |
| 3. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлт | 20% | | Захирал | | |
| | | | | Ерөнхий инженер | | |
| 4. | Цаг ашиглалт, олон нийтийн ажилд оролцсон байдал, ёс зүй харилцаа хандлагын зөрчилгүй, Газрын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрэм, журмын зөрчилгүй байдал | 15% | | Хууль, гэрээний мэргэжилтэн | | |
| | | | | Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн | | |
| 5. | Ажлын чанар, горим ажиллагаа, бусад дүрэм, заавар мөрдөж ажилласан байдал | 10% | | Ерөнхий инженер | | |
| 6. | Төлбөрт үйлчилгээний захиалгын хуудас болон гэрээгээр гүйцэтгэсэн ажлын мэдээ тайлан, баримтыг тухай бүрт нь Санхүү борлуулалтын албанд хүлээлгэн өгсөн байдал. | 10% | | Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга | | |
| 7. | Мэдээ, тайлан хугацаанд нь гаргасан байдал, өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт | 10% | | Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга | | |
| | | | | Ерөнхий нягтлан бодогч | | |
| | Дүн | 100% | | | | |

Дүгнэсэн: УХАТ-ын хэсгийн дарга .................................... /..................................../

Захирлын 2021 оны 12 сарын 27 ны 7/139 дугээр
тушаалын хоёрдугаар хавсралт, хүснэгт №10

БАТЛАВ: "ЗҮДС" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ ................................/ О.ТӨМӨРХУЯГ /

## Удирдлагын ......... сарын үр дүнгийн нэмэгдэл олгох хувь тооцох хүснэгт

......он......сарын.....өдөр

| Д/д | Үзүүлэлт | Олгох ёстой хувь | Олгосон хувь | Дүгнэх албан тушаалтан | Гарын үсэг | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өгсөн үүрэг даалгавар, төлөвлөгөөний биелэлт, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлүүлж, хариу өгсөн байдал | 20% | | Захирал | | |
| 2 | Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын зөрчилгүй байдал, дотоод хяналтын албанаас ирүүлсэн зөвлөмж, үүрэг даалгаварыг хугацаанд нь биелүүлсэн, тайлагнасан байдал | 10% | | Захирал | | |
| 3 | Хариуцсан ажлын чанар, тоноглолын бэлэн байдал, горим ажиллагаа, мэдээ тайлан хугацаанд нь гаргах, ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлж ажилласан байдал | 30% | | Захирал | | |
| 4 | Цаг ашиглалт, олон нийтийн ажилд оролцсон байдал, ёс зүй харилцаа хандлагын зөрчилгүй, Газрын дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, бусад дүрэм, журмын зөрчилгүй байдал | 20% | | Хууль, гэрээний мэргэжилтэн | | |
| | | | | Хүний нөөц, сургалт хариуцсан мэргэжилтэн | | |
| 5 | ХАБЭА хууль, дүрмийг мөрдөж зөрчилгүй ажилласан байдал | 20% | | ХАБЭА инженер | | |
| Дүн | | 100% | | | | |

Дүгнэсэн: Захирал .................................... /О.Төмөрхуяг/

Захирлын 2023 оны 12 сарын 27 ны Б/39 196 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт, хүснэгт №11

БАТЛАВ: "ЗҮДС" ТӨҮГ-ЫН ЗАХИРАЛ
................................/О.ТӨМӨРХУЯГ/

## ...........................ХЭЛТЭС, АЛБА, ХЭСГИЙН АЖИЛЧДАД .............. САРЫН ҮР ДҮНГИЙН ХУВЬ ТООЦОХ ХҮСНЭГТ

| № | Ажилчдын нэрс | Олгох хувь | Олгосон хувь | ХАБЭА-н зөрчилгүй ажилласан байдал | Ажлын байрны тодорхойлолтоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн байдал | Ажлын цаг ашиглалт | Өгсөн үүрэг даалгаврын биелэлт | Ёс зүй харилцаа хандлагын зөрчилгүй, нийтийн ажилд оролцсон байдал | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |
| | | | | | | | | | |